



Mongolian Child Development Research **2024**

International
SCIENTIFIC CONFERENCE

Ulaanbaatar, Mongolia - 21 May, 2024

**“MONGOLIAN CHILD DEVELOPMENT RESEARCH – 2024”
INTERNATIONAL SCIENTIFIC CONFERENCE AGENDA**

Date: Tuesday, 21 May, 2024

Venue: #502 Conference hall, NUM (National University of Mongolia) Library

11:30 12:00	Registration
12:00 12:10	Opening remarks <i>Itgel, M. (Ph.D.) Director. (Mongolian National Institute for Educational Research)</i>
12:10 12:25	Mongolian Child Development Research: Past, Present and Future Needs <i>Bez, N. Academician (Mongolian National Institute for Educational Research)</i>
12:25 12:40	A study on child development of Mongolia (school aged children) <i>Sanjaabadam, S., Enkhbayar, B., Lkhagvasuren, Ts., Bayarmaa, B., Bayasgalan, E. (MNIER)</i>
12:40 12:55	Mongolian schoolchildren growth trend for the past 50 years: meta-analysis <i>Munkhzhaya, M., Undram, L., Ser-Od, Kh., Khuderchuluun, N., Tsolmon, Ch. (MNUMS-School of Public Health)</i>
12:55 13:10	A Comparative Study of the “Dragon Maiden Repaying a Favor” Narrative between Mongolian and Han Chinese from the Perspective of Variology <i>Li Fang (Baotou Teachers’ College, Inner Mongolia University of Science and Technology)</i>
13:10 13:25	Modern trends of characteristics of physical growth and development of mongolian children <i>Gundegmaa, L., Bat-Erdene, Sh. (The National Institute of Physical Education)</i>
13:25 13:40	An analysis of the research methods utilized in master thesis and dissertations in the field of early childhood development <i>Batdelger, J., Javzandulam, B. (MNUE)</i>
13:40 13:55	Discussions
13:55 14:10	Coffee break
14:10 14:25	Joint Russian-Mongolian Studies in Human Auxology <i>Godina E.Z. (Research Institute and Museum of Anthropology, Lomonosov Moscow State University, Russia)</i>
14:25 14:40	Comparative Analysis of the Significance of Future Vision in Foreign Language Learning in Upper Secondary Schools of Ulaanbaatar: A Focus on International Chinese and English Learning <i>Wu Wenshu, Yang Wenting (Baotou Teachers’ College), Bez Nadmid (MNIER), Ariunaa Dashtseren (MNUE)</i>
14:40 14:55	Some results of a study of the socio-emotional and cognitive development of children with special educational needs <i>Bayasgalan, E. Enkhbayar, B. Sanjaabadam, S., Lkhagvasuren, Ts., Bayarmaa, B. (MNIER)</i>
14:55 15:10	Research on the Concept and Attitude of Inclusive Education among Kindergarten Teachers in Inner Mongolia Autonomous Region <i>Han Sarina (Baotou Teachers’ College, Inner Mongolia University of Science and Technology)</i>
15:10 15:25	Study of childhood obesity <i>Otgon, G., Tsolmon, Ch., Achsaikhan, G., Bathishig, B., Usukhbayar, Ch., Tsetsegdolgors, D., Munkhsoyol, E., Sarangerel, D. (MNUMS)</i>

15:25 15:35	Features of Biological Maturity of Children from 3 to 18 Years Old with Various Body Types <i>Komissarova, E.N. (Herzen Russian State Pedagogical University)</i> <i>Shkut, E.N. (Children's City Clinical Hospital No. 5 named after N.F. Filatov (Russia))</i>
15:35 15:50	Discussions
15:50 16:00	Coffee break
16:00 16:15	A Study on the Relationship between Parenting Styles and Emotion Regulation Strategies among Mongolian University Students in Inner Mongolia Autonomous Region <i>Liu Junying (Baotou Teachers' College, Inner Mongolia University of Science and Technology)</i>
16:15 16:30	Responsive care of parents and guardians of young children in Mongolia <i>Bulganzaya, T., Tsendsuren, T. (MNUE)</i> <i>Amarjargal, T. (SICA)</i>
16:30 16:45	The Narrative of Growth and Identity Construction in Ethnic Minority Children's Novels: A Study of "The Children of Ulan Muqir," "Three Caterpillars," and "The Lonely Tree" <i>Wang Min (Baotou Teachers' College, Inner Mongolia University of Science and Technology)</i>
16:45 16:55	Effectiveness of the Exercise Intervention on Academic Achievement among Elementary School Children <i>Ai Aoki, Ganchimeg, T., Akihito Kikuchi, Takemune Fukuie, Bat-Erdene, Sh, Kazuya Suwabe, Masashi Mikami, Rintaro Mori, Hideaki Soya, Kenji Takehara.</i> <i>(National Center for Child Health and Development, Japan)</i>
16:55 17:10	Level of resilience students (On the example of the results of mathematics test of the 9 th grade students) <i>Sansarmaa, Kh. (MNUE), Soyoljin, S. (NUM)</i>
17:10 17:25	The study results of budget support for the development of young children <i>Gansukh, T., Irvs, O., Battsengel, B., Bayartsetseg, B (MNIER)</i>
17:10 17:25	Discussions
17:25 17:40	Closing

**“МОНГОЛ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА – 2024”
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР**

Хэзээ: 2024 оны 5-р сарын 21-ний өдрийн 12:00-18:00

Хаана: МУИС-ийн Төв номын Сан, # 502, Монгол Улс, Улаанбаатар хот.

Оролцогчид: Монгол Улс, БНХАУ, ОХУ, Японы эрдэмтэн, судлаачид

11:30 12:00	Бүртгэл
12:00 12:10	Нээлтийн үг <i>М.Итгэл, Захирал</i> (<i>Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн</i>)
12:10 12:25	Монгол хүүхдийн хөгжлийн судалгаа: өмнөх үе, одоо, хойшдын хэрэгцээ <i>Н.Бэгз Академич (Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн)</i>
12:25 12:40	Монгол хүүхдийн хөгжлийн онцлогийг судалсан үр дүнгээс (сургуулийн нас) <i>С.Санжаабадам, Б.Энхбаяр, Ц.Лхагвасүрэн, Б.Баярмаа, Э.Баясгалан</i> (<i>БСҮХ</i>)
12:40 12:55	Сүүлийн 50 гаруй жилийн сургуулийн насны хүүхдийн бие бялдрын өсөлтөд хийсэн мета-анализ судалгаа <i>М.Мөнхзаяа, Л.Ундрам, Х.Сэр-Од, Н.Хүдэрчулуун, Ч.Цолмон (АШУИС-НЭМС)</i>
12:55 13:10	A Comparative Study of the “Dragon Maiden Repaying a Favor” Narrative between Mongolian and Han Chinese from the Perspective of Variology <i>Li Fang (Baotou Teachers’ College, Inner Mongolia University of Science and Technology)</i>
13:10 13:25	Монгол хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжлийн онцлогийн орчин үеийн чиг хандлага <i>Л.Гүндэгмаа, Ш.Бат-Эрдэнэ (ҮБТДС)</i>
13:25 13:40	Бага насны хүүхдийн хөгжлийн чиглэлээр хамгаалсан эрдмийн ажлын судалгааны арга зүйд хийсэн шинжилгээ <i>Ж.Батдэлгэр, Б.Жавзандулам (МУБИС)</i>
13:40 13:55	Асуулт, хариулт
13:55 14:10	Цайны завсарлага
14:10 14:25	Joint Russian-Mongolian Studies in Human Auxology <i>Godina E.Z. (Research Institute and Museum of Anthropology, Lomonosov Moscow State University, Moscow, Russia)</i>
14:25 14:40	Comparative Analysis of the Significance of Future Vision in Foreign Language Learning in Upper Secondary Schools of Ulaanbaatar: A Focus on International Chinese and English Learning <i>Wu Wenshu, Yang Wenting (Baotou Teachers’ College), N.Begz (MNIER), D.Ariunaa (MNUE)</i>
14:40 14:55	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн нийгэмшил ба танин мэдэхүйн хөгжлийн тандах судалгааны зарим үр дүнгээс <i>Э.Баясгалан, Б.Энхбаяр, С.Санжаабадам, Ц.Лхагвасүрэн, Б.Баярмаа (БСҮХ)</i>
14:55 15:10	Research on the concept and attitude of inclusive education among kindergarten teachers in Inner Mongolia Autonomous Region <i>Han Sarina (Baotou Teachers’ College, Inner Mongolia University of Science and Technology)</i>
15:10 15:25	Хүүхдийн таргалалтыг судлах <i>Г.Отгон, Ч.Цолмон, Г.Ачсайхан, Б.Батхишиг, Ч.Өсөхбаяр, Д.Цэцэгдолгор, Э.Мөнхсөёл, Д.Сарангэрэл (АШУИС)</i>

15:25 15:35	Особенности биологической зрелости детей с 3 до 18 лет, обладающих различными типами телосложения <i>Е.Н.Комиссарова (РГПУ им. А.И.Герцена), Е.Н.Шкут (клиническая больница № 5 им. Н.Ф.Филатова)</i>
15:35 15:50	Асуулт, хариулт
15:50 16:00	Цайны завсарлага
16:00 16:15	A Study on the Relationship Between Parenting Styles and Emotion Regulation Strategies Among Mongolian University Students in Inner Mongolia Autonomous Region <i>Liu Junying (Baotou Teachers' College, Inner Mongolia University of Science and Technology)</i>
16:15 16:30	Бага насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдын хариу үйлдэлт асаргааг судалсан нь <i>Т.Булганзаяа, Т.Цэндсүрэн (МУБИС), Т.Амаржаргал (“Эс Ай Су Эй” ХХК)</i>
16:30 16:45	The Narrative of Growth and Identity Construction in Ethnic Minority Children’s Novels: A Study of “The Children of Ulan Muqir,” “Three Caterpillars,” and “The Lonely Tree” <i>Wang Min (Baotou Teachers' College, Inner Mongolia University of Science and Technology)</i>
16:45 16:55	Effectiveness of the exercise intervention on academic achievement among elementary school children <i>Ai Aoki, Ganchimeg, T, Akihito Kikuchi, Takemune Fukuie, Bat-Erdene, Sh, Kazuya Suwabe, Masashi Mikami, Rintaro Mori, Hideaki Soya, Kenji Takehara. (National Center for Child Health and Development, Japan)</i>
16:55 17:10	Резилиенс сурагчдын түвшин (9-р ангийн сурагчдын математикийн тестийн үр дүн дээр) <i>Х.Сансармаа (МУБИС) С.Соёлжин (МУИС)</i>
17:10 17:25	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжсэн төсвийн судалгааны зарим үр дүнгээс <i>Т.Гансүх, О.Ирвэс, Б.Батцэнгэл, Б.Баярцэцэг (БСҮХ)</i>
17:10 17:25	Асуулт, хариулт
17:25 17:40	Хаалт

“МОНГОЛ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА-2024” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН НЭЭЛТИЙН ҮГ

Доктор М.ИТГЭЛ (Ph.D.)

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал

Бидний зохион байгуулж байгаа “Монгол хүүхдийн хөгжлийн судалгаа-2024” олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэлээ хэлэлцүүлж, илтгэлээ нийтлүүлж байгаа Монгол Улс, БНХАУ, ОХУ, Япон улсын эрдэмтэн, судлаач, багш нар та бүхний энэ өдрийн амгаланг эрье.

Мөн манай хуралд урилгаар оролцож байгаа хүндэт зочид, БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын болон МУ-ын ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын удирдлага, ШУА-ийн Нийгмийн шинжлэх ухааны салбарын Бага чуулганы төлөөлөл, бүх шатны сургуулийн багш нар, мастер, доктор оюутнууд та бүхэнд БШУЯ-ны Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн хамт олны өмнөөс мэндчилгээ дэвшүүлье.

Та бүхэн сайхан зусаж байна уу?

Ирж буй цагийн эрэлтэд нийцүүлэн, хувьсан өөрчлөгдөж буй боловсролын үзэл санааг Монгол Улсдаа хэрэгжүүлэх энэ түүхэн цаг үед, сургалтын харилцаанд оролцогч гол субъектийн нэг монголын хүүхэд, залуусаа СӨБ, бага, дунд, дээд боловсролын түвшинд сургаж, нийгмийн иргэнээ хөгжүүлэн төлөвшүүлэх зорилтыг хангахад тэдний сурах хэрэгцээ, мэдээлэл хүлээн авч мэдлэгийг чадвар болгох, дадал хандлагыг төлөвшүүлэх боломжийг судлан тогтоох нь та бидний өмнө олон шинжлэх ухааны оролцоотой боловсрол судлалын илүү чухал асуудлуудыг дэвшүүлэн гаргаж ирж байна.

Манай Улсад хүүхэд судлал ХХ зууны эхнээс шинэ цагийн боловсролын байгууллага үүсэн байгуулагдсан тэр үеэс эхэлснийг ахмад үеийнхний эрдэм судлалын ажлын өв сангаас харж болдог. Энэхүү судалгаа нь цаг үеийнхээ онцлогийг хадгалсан, хүүхэд залуучуудынхаа хүмүүжил, сургалтын ажлын чанарыг сайжруулахад чиглэж, социалист, коммунист үзэл санааны хүрээнд тэр үеийнхээ нийгмийн захиалгад нийцсэн агуулга бүхий сургалт, хүмүүжлийн ажил явж байсныг харуулдаг.

Монгол Улс өнөөдөр хүн төрөлхтний нийтлэг эрх ашигт нийцсэн, хувь хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, хэнийг ч ялгаварлалгүйгээр бүх нийтийг сургалтын харилцаанд эрх тэгш оролцуулах боловсролын бодлого явуулж байна. Үүнийг хэрэгжүүлэхэд суралцагч бүхний дахин давтагдашгүй онцлогийг харгалзан, тэдний нас насны сурах хэрэгцээг хангах үндэсний онцлогтой, шинжлэх ухааны үндэстэй, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийн баримжаатай боловсролын үйлчилгээ шаардагдаж байна. Бид үүнийг хэрэгжүүлэхдээ монгол хүүхдийнхээ төрмөл унаган шинжийг харгалзаж, ирээдүйд амьдрах нийгмийнх нь шаардлагыг хангаж чадахуйцаар сургаж, хүмүүнжүүлэхийн тулд тэднийхээ онцлог, нийтлэгийн судалгааг өндөр түвшинд явуулахыг чармайж байна.

Өнгөрсөн 20-иод жилд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, МУИС, МУБИС, Үндэсний биеийн тамирын дээд сургууль, төрийн бус байгууллагын эрдэмтэн судлаачид монгол хүүхдийн судалгааг өөр өөрийн чиглэлээр тасралтгүй явуулж ирлээ. Тухайлбал, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Хүний хөгжлийн судалгааны секторын судлаачид дээр дурдсан их сургуулиуд, байгууллагын судлаач эрдэмтдийн зөвлөмж туслалцаатайгаар, монгол хүүхдийн цогц хөгжлийн судалгааны аргазүйг боловсруулж, 2014 оноос эхлэн 2 шаттайгаар уг судалгааг хэрэгжүүлж, үр дүнг нь БШУЯ-нд хүлээлгэн өгөөд, гурав дахь шатны судалгааны бэлтгэл хангаж байна. Энэ болон өмнөх олон судалгаанд хамтран ажиллаж, тус дэм үзүүлж байсан байгууллага, эрдэмтдэд талархлаа илэрхийлье.

Монголын хүүхэд, залуусын бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийн онцлогийг тогтоох, алс нь нас насны монгол хүний хөгжлийн стандарт тогтоох том зорилт нь ганц удаагийн оролдлогоор тогтоочихдог ч эд биш, урт хугацааны давтан судалгаа шаарддаг, олон шинжлэх ухааны эрдэмтдийн оролцоотойгоор хийгддэг нүсэр ажил байдаг юм байна. Бид энэ ажлаа амжилттай үргэлжлүүлж, нийгмийн хөгжлийн захиалгыг биелүүлэхийн төлөө хичээн ажиллах болно. Манай улсын холбогдох бусад их сургуулиуд, судалгааны хамтлагууд ч өөр өөрийн чиглэлээр судалгааны ажлаа үргэлжлүүлж байгаад талархаж байна.

Монгол хүүхдийн хөгжлийн судалгааны агуулгаар эхэлж байгаа энэ удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хуралд 4 орны их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл 48 эрдэмтэн, судлаач оролцож бэлтгэсэн хүүхдийн хөгжлийн судалгааны уламжлал шинэчлэл, хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, оюун санаа, нийгэмшлийн болон хэл ярианы хөгжил төлөвшлийн зэрэг өргөн хүрээний асуудал хамарсан 18 илтгэл хэлэлцэх гэж байна. Энэ хурал цаашдаа хүүхдийн хөгжлийн судалгааны аргазүй, үйл явц, үр дүнг олон улсын хэмжээнд тогтмол хэлэлцдэг, энэ чиглэлийн судлаач эрдэмтдийн мэдлэг, туршлагаа солилцдог бүс нутгийн хэмжээний тогтмол давтамжтай эрдэмийн индэр болно гэж найдаж байна. Бидний уриалгыг ойлгон дэмжиж, та бидний ирээдүй болсон хүүхэд залуусынхаа сурах, хөгжих асуудлын судалгаанд цаашид хамтран ажиллана гэдэгт та бүхэнд итгэж байна.

Ингээд өнөөдрийн энэ “Монгол хүүхдийн хөгжлийн судалгаа-2024” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал албан ёсоор нээгдсэнийг мэдэгдэж, үйл ажиллагаанд нь амжилт хүсье.

Баярлалаа.

МОНГОЛ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА: ӨМНӨХ ҮЕ, ОДОО, ХОЙШДЫН ХЭРЭГЦЭЭ

Академич Надмидын БЭГЗ

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн



Хураангуй

Боловсрол хэрэгцээгээр үүсэж, хөгждөг тул суралцагчаа судлах нь монголын боловсрол судлалын нэг үндсэн үүрэг юм. Өнгөрсөн XX зууны эхнээс өнөөг хүртэл монгол хүүхдийн хөгжлийн судалгаа манай оронд хэрхэн явж ирсэн, түүний одоогийн байдал, хойшдынх нь хэрэгцээ ямар байх талаар зохиогчийн үзэл санааг тусгасан өгүүллээ бэлтгэлээ. Үүнийг бичихдээ XX зуун, XXI зууны эхний 20-иод жилд монголын боловсролын судалгаа, арга зүйн голлох мэргэжилтнүүд хүүхдийн хөгжлийн асуудлаар бичиж нийтлүүлж байсан бүтээлүүдийн судалгааны чиглэл, хамарсан хүрээг гаргах зорилт тавьж, баримт бичгийн шинжилгээний аргыг хэрэглэв.

Энэ зорилгоор “Сурган хүмүүжүүлэгч” сэтгүүлийн 1930-1969 оны дугаарууд, Боловсролын хүрээлэнгийн 45 жилийн ойд зориулж 2001 онд гаргасан *XX зууны монголын боловсрол судлал, Монголын боловсрол судлаач эрдэмтдийн сонгомол өгүүллийн түүвэр* зэрэг эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэлүүдээс манай боловсролын системийн хөгжилд хувь нэмрээ оруулж явсан төр, шинжлэх ухааны зүтгэлтнүүд, эрдэмтэд, судлаачдын 1921-1999 оныг хамрах бүтээлийг авч дүгнэлт хийв. Мөн 1958-2021 онд боловсрол судлалаар хамгаалсан монгол эрдэмтдийн диссертацууд, *Боловсрол судлал* сэтгүүлийн 2002-2024 онд нийтлэгдсэн 200 дугаарт байгаа хүүхдийн хөгжлийн асуудлаар бичигдсэн өгүүллүүдийг хамруулж авч үзлээ. Өгүүлэлд манай эрдэмтдийн оролцоотойгоор 1991 оноос хойш хийгдсэн монгол хүүхдийн судалгаануудын үр дүнгээс, тухайлбал, Боловсролын хүрээлэнгийн эрдэмтдээс 2013-2022 онд анх удаа явуулсан монгол хүүхдийн цогц хөгжлийн судалгааны дүнг тусгалаа.

Үүний дүнд монгол хүүхдийн хөгжлийн асуудлаар хийгдсэн судалгааны чиглэл, хамарсан хүрээний тойм гарч, цаашид монгол хүүхдийн цогц судалгааг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлох боломж гарч байна.

Түлхүүр үг: хүүхдийн сурлага, хүмүүжил, нийгэмшил, цогц хөгжил.

MONGOLIAN CHILD DEVELOPMENT RESEARCH: PAST, PRESENT AND FUTURE NEEDS

Academician BEGZ Nadmid

Mongolian National Institute for Educational Research

Abstract

Education arises and develops according to needs, studying students is one of the main tasks of mongolian educational studies. I have prepared an article that reflects the author's ideas about how mongolian child development research has progressed in our country from the beginning of the 20th century to the present, its current status, and what its needs will be in the future. In writing this, we set the goal of creating a research direction and comprehensive scope of the works that were written and published by the main experts in mongolian educational research and methodology in the 20th century and the first 24 years of the 21st century, and used the document analysis method.

Also, the dissertations of Mongolian scientists defended in education studies in 1958-2021, and the articles written on the issue of child development in the 2002-2024 issue of the Journal of Education were considered. The article reflects the results of mongolian children's research conducted since 1991 with the participation of our scientists. For example, the article reflects the results of the research on comprehensive development of mongolian child conducted in 2013-2022 by the scientists of the Institute of Education.

As a result, there is an overview of the direction and scope of research conducted on the development of mongolian child, and an opportunity to determine the future direction on it's comprehensive research.

Keywords: education, upbringing, social-emotional and comprehensive development of children.

МОНГОЛ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГИЙГ СУДАЛСАН ҮР ДҮНГЭЭС (Сургуулийн нас)

**С.Санжаабадам, Б.Энхбаяр, Б.Баярмаа,
Ц.Лхагвасүрэн, Э.Баясгалан**

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн



Хураангуй

БСҮХ-ийн судалгааны баг нь БШУЯ-ны захиалгаар, ШУТС-ийн санхүүжилтээр монгол хүүхдийн цогц хөгжлийн судалгааг 2019-2021 онд гүйцэтгэсэн. Судалгааны зорилго нь 3-17 насны хүүхдийн цогц хөгжлийн онцлог тогтоох, нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх юм. Судалгааг бодит хэмжилтийн арга, сэтгэл зүйн сорилыг хэрэглэн явуулсан. Бидний эхний судалгаанд 3164, 2 дахь судалгаанд 4019 хүүхэд оролцсон.

Энэхүү илтгэлээрээ 6-17 настай хүүхдүүдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн чадваруудын онцлогийг судалгааны үр дүнд үндэслэн танилцуулахыг зорилоо.

Хүүхдийн биеийн өсөлтийн эрчимтэй үе нь өсвөр нас ба нийгмийн хөгжлөө дагаад тодорхой хугацааны дараа хүүхдүүдийн өсөлтийн дундаж үзүүлэлтүүд нэмэгдсэн байна. Энд нийгэм орчны олон хүчин зүйл нөлөөлсөн байх бүрэн боломжтой.

Бие бялдрын бэлтгэлжилтийн чанарын тухайд хүүхдүүдийн уян хатан, тэсвэрт чанарыг дэмжих хэрэгцээ харагдлаа.

Судалгаагаар нас нэмэгдэх тусам хүүхдүүдийн мэдээллийг хүртэж хүлээж авах болон хийсвэр сэтгэхүйн чадварууд өссөн байна. Бүхий л насанд хүүхдүүдийн сэтгэхүйн ангилах нь сэтгэхүйн ерөнхийлөн дүгнэх чадвартай харьцуулахад харьцангуй сайн байна. Хүүхдүүдийн танин мэдэхүйн хөгжилд бодит шинж давамгайл байна.

Нийгэмшлийн чадварыг судалсан үр дүнгээс харахад, өсвөр насанд хүүхдүүдийн өөртөө хандах хандлага, харилцааны чадварыг сайжруулахад үйл ажиллагааг чиглүүлэх нь хөгжлийг дэмжих нэг чиглэл байна.

Түлхүүр үг: 6-10 насны хүүхэд, 11-14 насны хүүхэд, 15-17 насны хүүхэд, бие бялдрын өсөлт, бие бялдрын бэлтгэлжилт, танин мэдэхүйн хөгжил, нийгэмшлийн чадваруудын онцлог.

A STUDY ON CHILD DEVELOPMENT OF MONGOLIA (SCHOOL AGED CHILDREN)

Sanjaabadam,S., Enkhbayar,B., Lkhagvasuren,Ts., Bayarmaa,B., Bayasgalan,E

Mongolian National Institute for Educational Research

Abstract

The Mongolian national institute for educational research conducted research on children development of Mongolia from 3 to 17 aged commissioned by the Ministry of Education and Science and funded by Found of Science and Technology from 2019 to 2021.

The purpose of the research was to detect characteristics of complex development of children aged 3-17 years and some factors on the development.

Objective methods for physical measurement and psychological tests were used in the research. The research was provided in 2 stages. The two stage research were participated 3164 children in 1-st stage and 4019 children 2-nd stage.

The aim of the report is to introduce some results on characteristics of physical, socio-emotional and cognitive development of children aged 6-17.

According to the results for physical development, intensive period of development is adolescence and some physical indicators were increased correlating with social change or development. Many factors could be influenced on these growth.

According to the results of physical fitness, flexibility and muscle endurance of the children need to develop by physical training.

In the study results of the cognitive development were detected that abilities of receiving information and abstract thinking increase correlating with children ages. Also, at all ages thinking categorization ability was relatively good compared to thinking generalization ability. The research detected that cognitive development of the children was dominated by more reality.

In the study results of the socio-emotional skills of the children, was detected that we need to improve their self assurance and social-emotional skills.

Keywords: children 6-10 years old, children 11-14 years old, children 15-17 years old, characteristics of physical growth, physical preparation, cognitive development, and socio-emotional.

СҮҮЛИЙН 50 ГАРУЙ ЖИЛИЙН СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ӨСӨЛТӨД ХИЙСЭН МЕТА-АНАЛИЗ СУДАЛГАА


М.Мөнхзаяа¹, Л.Ундрaм², Х.Сэрд-Од³,
Н.Хүдэрчулуун⁴, Ч.Цолмон¹

¹АШУУИС, Нийгмийн эрүүл мэндийн сургууль,
Шим тэжээл судлалын тэнхим

²АШУУИС, Нийгмийн эрүүл мэндийн сургууль,
Эрүүл мэндийн бодлогын тэнхим

³АШУУИС, Нийгмийн эрүүл мэндийн сургууль,
Эпидемиологи Биостатистикийн тэнхим

⁴Санхүүгийн зохицуулах хороо



Хураангуй

Хүүхдийн бие бялдрын өсөлтийн өөрчлөлт, түүний хөдлөл зүйг олон жилийн хандлага, цаг хугацаагаар хүн амын насны бүлгүүдэд өөрчлөгдөж буй зүй тогтлыг судлан тогтоох нь улс орнуудын тулгамдсан асуудал юм. Нэг зуунаас нөгөө зуунд шилжихэд хүүхдийн өсөлт хөгжилд гарч буй өөрчлөлт антропометрийн үзүүлэлтүүд өөрчлөгдөж байгаагаар илэрдэг байна. Сургуулийн насны хүүхдийн бие бялдрын өсөлтийн төлөв байдал, сүүлийн 50 гаруй жилд гарч буй өөрчлөлтийг судлан тогтоох.

Улаанбаатар хотын 6-17 насны нийт 8046 хүүхдийг хамруулан насны бүлэг, хүйс болгонд өсөлтийн дундаж үзүүлэлтүүдийг LMS-ийн аргаар тогтоон, Мета-анализын аргаар цаг хугацааны өөрчлөлтийн төлөвийг ижил нас, хүйсийн хүүхдийн өндөр ба жингийн дунджуудтай харьцуулалт хийж тогтоосон. Ингэхдээ 1962, 1978, 1992 оны Монгол улсад албан ёсоор баталгаажсан хүүхдийн стандартуудыг ашигласан. Мета-анализын нөлөөллийн хэмжээг утгуудын стандарт ялгааг тооцох Кохен d коэффициентоор үнэлэн, боловсруулалтад SPSS-26 программ ашиглан, судалгааг 2015-2020 онд хийсэн.

Өсөлтийн хурдац “цаг хугацаанд” хэрхэн өөрчлөгдөж буйг харьцуулахад 90-ээд оных 70-аад оныхоос ердөө 1.1см илүү өндөртэй, 90-ээд оны хөвгүүд 10-12 насандаа 20 гаруй өмнөх жилийн үе чацуутнаасаа намхан болсон бол охид 0.8см намхан болсон нь тогтоогдсон. Ийнхүү судалгаагаар 2010 он хүртэл өсөлт харьцангуй өссөн үзүүлэлттэй, 2020-иод оноос хүйс ялгалгүй өндөр, жин буурч эхэлсэн байна.

Түлхүүр үг: акцелераци, децелераци, нас-хүйсний бүлэг.

MONGOLIAN SCHOOL CHILDREN GROWTH TREND FOR THE PAST 50 YEARS: A META-ANALYSIS

Munkhzaya,M¹., Undram,L¹., Ser-Od,Kh¹.,
Khuderchuluun,N²., Tsolmon,Ch¹

¹*MNUMS, School of Public Health*

²*Financial regulatory commission*

Abstract

Growth rates increase and decrease during childhood were named as secular trends, which have occurred during last 50-100 years. These trends vary from country to country, and there is a need to study the phenomenon in Mongolian children. Normalised growth centile of 8046 children were compared to previous years standard values. Effect size in height in boys was $d=0.7$ in 1962-1978, which means boys in 1978 were 4.1 cm taller their counterparts in 1962. But in 1992, 66%, 50%, and 69% of boys aged 10-12 years old were shorter of boys of the same age in 1978, having Cohen d as -0.4, -0.1 and -0.5 respectively. Girls' growth trend shows similar pattern to boys' one. There was only 1.1 cm increase in boys height during 20 years period of time, and 0.8 cm decrease in girls height. In terms of weight there was increase for the first 20 years of period with consecutive decrease in girls aged 10-13 years. An acceleration phenomenon observed in Mongolia children growth has diminished for the past 50 years, and deceleration progressed for the past 20 years.

Keywords: child growth, acceleration, deceleration, Cohen d .

A COMPARATIVE STUDY OF THE “DRAGON MAIDEN REPAYING A FAVOR” NARRATIVE BETWEEN MONGOLIAN AND HAN CHINESE FROM THE PERSPECTIVE OF VARIOLOGY

Li FANG

*Inner Mongolia University of Science and Technology,
Baotou Teacher's College*



Abstract

Originating from India, the tale of the Dragon Maiden gradually transformed into a narrative with distinct Chinese characteristics known as the “Dragon Maiden Repaying a Favor” upon entering China. During this evolutionary process, Han Chinese culture laid the foundational cultural basis for the story and played a crucial role in the early formation of the Chinese Dragon Maiden narratives. In the course of interaction, communication, and integration between the Mongolian and Han ethnic groups, the Mongolians not only participated in the preservation and dissemination of the same motif but also enriched the cultural connotation of the motif in their unique way. They even developed types of motifs in the same category of stories, contributing to the diverse formation of the Chinese Dragon Maiden tales.

Keywords: variology, MongolianHan, Dragon Maiden Repaying a Favor, Narrative Types

变异学视域下蒙汉“龙女报恩”类型比较

李芳

包头师范学院 教育科学学院 内蒙古包头

论文摘要

论文摘要：龙女故事源自印度，进入中国后，逐渐演变为中国特色的龙女报恩故事，在这个演变过程中，汉族文化奠基了中国龙女报恩故事的主要文化基础，在中国龙女故事形成的早期发挥了重要作用。在蒙汉民族交往交流交融的过程中，蒙古族不仅参与了同一母题的保存与传播，同时又以自身独特的方式增值了同一母题的文化内涵，甚至发展了同一类故事的母题类型，为中国龙女故事形成百花齐放的形态做出了贡献。

关键词：变异学 蒙汉 龙女报恩 故事类型

МОНГОЛ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ӨСӨЛТ ХӨГЖЛИЙН ОНЦЛОГИЙН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

Л.Гүндэгмаа¹, Ш.Бат-Эрдэнэ²

^{1,2} Үндэсний Биеийн Тамирын Дээд сургууль



Хураангуй

Хүүхэд өсвөр үеийн эрүүл мэндийн байдал нь тухайн хүүхдийн нас хүйсэнд тохирсон бие бялдрын болон оюуны өв тэгш хөгжилт, хэвийн үйл ажиллагааны төвшингөөр тодорхойлогдоно. Иймд хүүхдийн эрүүл мэндийг хамгаалан, бэхжүүлэхэд чиглэсэн олон асуудлыг шийдвэрлэхэд өсөлт бойжилтын явцад бие махбодид явагдах биологийн өөрчлөлтийн шинж төрхийг заавал харгалзан үзэх шаардлагатай. Хүүхдийн өсөлт хөгжилтийн үзүүлэлтийг байнга авах нь тухайн улс орон хүүхдүүдэд зориулах хувцас, ширээ сандал, тоног төхөөрөмжийн хэмжээ, хэрэгцээг гаргах Засгийн газраас хүүхдэд анхаарал тавих бодлого боловсруулж, эрүүл ахуйн асуудлуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм (Laura E. Berk, 2012)

Монголын хүүхэд, өсвөр үеийнхний бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн онцлогийн орчин үеийн чиг хандлагыг тодорхойлох зорилготой. Судалгаандаа асуумж, антропометр, био-импедансиометр, спирометр, бие бялдрын сорил тест, математик боловсруулалтын аргуудыг хэрэглэсэн.

Энэ судалгаанд хүүхдийн биеийн бүтэц үйл ажиллагааны зүй тогтол хэрхэн бүрэлддэг болохыг тогтоох зорилгоор нас зүй, экологи, генетикийн хүчин зүйлтэй уялдуулан Монголын 8 настай хүүхдээс эхлэн өндөр зэрэглэлийн тамирчин хүртэлх 10 жилийн хугацаанд бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийг иж бүрэн судалсан өмнөх үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсрууллаа. Үүнд нийтдээ Монголын 9700 гаруй хүүхэд, өсвөр үе залуучуудаас судалж цуглуулсан материал багтана. Энэхүү судалгаанд Монголын ирээдүй үеийнхний биеийн бүтэц үйл ажиллагааны болон биеийн бүрдлийн шинэ үзүүлэлтүүдийг судалж гаргаснаар орчин үеийн хүн судлалын суурь судалгааны онолын болон практикийн чухал хувь нэмэр болохуйц үр дүн болсон. Насанд хүрсэн шигшээ багийн судлуулагч тамирчин бүрийн бие галбир, бэлтгэлжилтийн түвшинг тогтоож, модель загварыг тодорхойлов.

Түлхүүр үг: биеийн тамир, спорт, тамирчин, бие бялдрын бэлтгэлжилт, биеийн бүтэц, функциональ үзүүлэлт, гарын атгах хүч, хүчний тэсвэр, хурд, уян хатан, авхаалж самбаа.

MODERN TRENDS OF CHARACTERISTICS OF PHYSICAL GROWTH AND DEVELOPMENT OF MONGOLIAN CHILDRENS

Gundegmaa,L¹., Bat-Erdene,Sh²

^{1,2} National institute of Physical Education

Abstract

The health status of children and adolescents is determined by the level of physical and intellectual development and normal functioning appropriate to that child's age and sex. Therefore, in solving many problems aimed at protecting and strengthening children's health, it is necessary to take into account the nature of biological changes in the body during growth and puberty. Constantly obtaining indicators of children's growth and development is important for the government to determine the amount and needs of clothes, tables and chairs, and equipment for children, and to solve hygiene problems by the government (Laura E. Berk, 2012).

The purpose of the study is to determine the modern trends in the characteristics of physical development and preparation of children and adolescents in Mongolia. Questionnaires, anthropometry, bio-impedanceometry, spirometry, physical examination tests, and mathematical processing methods were used in the research. In this study, in order to determine how children's body structure and activity patterns are formed, in conjunction with age, ecology, and genetic factors, the previous parameters that comprehensively studied the physical development and training of Mongolian 8-17 years-old children. In total, it includes research and collected materials from more than 9700 children and adolescents in Mongolia. In this study, new parameters of the body structure, function and body composition of the future generations of Mongolia were studied, and the result was an important theoretical and practical contribution to the basic research of modern anthropology. The researcher of the adult national team established the physical shape and level of training of each athlete and defined the model model.

Keywords: physical activity, sport, athlete, physical training, body structure, functional parameters, hand grip strength, power endurance, speed, flexibility, agility.

JOINT RUSSIAN-MONGOLIAN STUDIES IN HUMAN AUXOLOGY

Godina Elena Z., Ph.D., D.Sc., professor

*Research Institute and Museum of Anthropology, Lomonosov
Moscow State University*



Abstract

The connections between academic circles of Russia and Mongolia were always very close.

Russian scientists have made a significant contribution to the study of the anthropological characteristics of the peoples of Central Asia. A special place in this list of names is occupied by the anthropological research of Academicians Tatyana and Valery Alekseevs, who devoted a considerable number of field trips and scientific works to studying the problem of interaction of human populations with the natural habitat in various ecological niches of Central Asia, including Mongolia. As a result of this field research a fundamental volume “Anthropoecology of Central Asia” was published (Alekseeva et al., 2005). Following the famous theory of adaptive types developed by Tatyana Alekseeva, the population of different geographical zones was analyzed. In most of the traits characterizing growth processes, representatives of different geographical zones showed similarities. Differences appeared only in the indicators of subcutaneous fat distribution.

The next stage of Russian-Mongolian academic cooperation refers to the beginning of the 21st century. Several research projects between Lomonosov Moscow State University and Mongolian National Institute of Physical Culture were developed and successfully realized. The main subject of these projects dealt with physical conditions of modern Mongolian children, adolescents and youth in the context of ethnogenetic, socioeconomic and ecological factors influencing growth. The impact of physical training and sport was also studied. Materials for molecular genetic analysis were collected from Mongolian youth athletes, data characterizing the somatic status of modern schoolchildren, young males and females living in various climatic and geographical zones, in rural and urban areas, in different living conditions were collected and analyzed. Based on this information, a huge database was created, statistical analyses performed, results presented as scientific papers and books. Some of these results will be discussed at the present conference.

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ХАМГААЛСАН ЭРДМИЙН АЖЛЫН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

(Магистр, докторын зэрэг горилсон судалгааны ажлын жишээн дээр)

Ж.Батдэлгэр, Б.Жавзандулам

МУБИС



Бидний илтгэлийн зорилго нь бага насны хүүхдийн хөгжлийн чиглэлээр Монгол улсын боловсролын их сургуулийн магистрантын дипломын болон докторын зэрэг хамгаалсан нэг сэдэвт бүтээл (2000-2023)-ийн судалгааны арга, арга зүйд дүн шинжилгээ хийж дүгнэлт өгөхөд чиглэсэн юм. Бага насны хүүхдийн хөгжлийн чиглэлээр хамгаалсан судалгааны ажилд горилогчид ямар арга зүйг ашигласан, зорилго, зорилтыг илрүүлэхүйц арга зүй сонгосон эсэх, түүний баталгаат чанарыг тогтоосон эсэх, олон улсад энэ чиглэлээр ямар арга зүйг ашигладаг, судлаачид гадаадын судлаачдын болон стандарчилсан арга зүй, аргыг өөрийн орны нөхцөл байдал, монгол хүүхдийн онцлогийг харгалзан тохируулга хийдэг эсэхийг судлах болно. Түүнчлэн судлаачдын сонгосон арга, арга зүйг хүүхдийн хөгжлийн гол чиглэлээр ангилах юм. Судалгаанд баримтад (магистрын дипломын болон нэг сэдэвт бүтээл) дүн шинжилгээ хийх чанарын аргыг үндсэн арга болгон ашиглана. Судалгааны үр дүнд магистрын дипломын болон докторын зэрэг горилсон эрдмийн ажилд хэрэглэсэн судалгааны арга, арга зүйн жагсаалт гарахын зэрэгцээ арга зүйн хөгжлийн төлөв байдал тодорхойлогдох юм.

Түлхүүр үг: судалгаа, бага насны хүүхэд, нэг сэдэвт бүтээл, судалгааны арга зүй.

AN ANALYSIS OF THE RESEARCH METHODS UTILIZED IN MASTER THESIS AND DISSERTATIONS IN THE FIELD OF EARLY CHILDHOOD DEVELOPMENT

Batdelger, J., Javzandulam, B

MNUE

Abstract

Our presentation aims to examine the research methodologies employed in studies for both master’s and doctoral degrees at the Mongolian University of Education, specifically focusing on the field of early childhood development. We intend to delve into the methods utilized by candidates in their defended research endeavors within this field, scrutinizing whether they effectively aligned their chosen methods with their objectives, ensuring the quality and rigor of their research. We’ll explore the international landscape of research methods prevalent in this field, investigating whether scholars integrated methodologies from foreign researchers and standardized tools while considering the unique context of Mongolia and the characteristics of Mongolian children. We’ll also assess the extent to which adjustments were made to accommodate these contextual nuances. Furthermore, we’ll categorize the methodologies adopted by researchers into key areas of child development, employing qualitative methods such as document analysis of master’s theses and doctoral dissertations as our primary investigative approach. By conducting this research, we aim to compile a comprehensive list detailing the array of research methods and methodologies employed in academic studies, shedding light on the current state of methodological development in this field.

Keywords: research, young children, dissertation, master thesis, research methodology.

COMPARATIVE ANALYSIS OF FOREIGN LANGUAGE LEARNING IN UPPER SECONDARY SCHOOLS OF ULAANBAATAR: A FOCUS ON INTERNATIONAL CHINESE AND ENGLISH LEARNING

Wu Wenshu¹, Yang Wenting¹,
Begz Nadmid³, Ariunaa Dashtseren⁴

¹*Baotou Teachers' College*

²*Mongolian National Institute for Educational Research*

³*Mongolian National University of Education*



Abstract

The study offers a comparative analysis of foreign language education in Ulaanbaatar's secondary schools. It methodically examines how these linguistic trends interact with Mongolia's educational strategies, noting the increase in Chinese learning prompted by China's enhanced global role and its economic corridor with Mongolia and Russia. This trend is assessed with the continuous worldwide necessity for English proficiency in global communication and business. The research evaluates how Ulaanbaatar's language education aligns with international economic and cultural exchanges and the development of educational policies. It differentiates the local motivations for learning Chinese from the universal demands of English proficiency. The study advocates for adaptable, future-oriented educational strategies that integrate global competencies with deep cultural roots, aiming to prepare students who are both globally proficient and culturally connected.

Keywords: International Chinese; English; Senior high school.

乌兰巴托市高中外语学习比较分析：

--以国际国际汉语和英语学习为例

本研究针对乌兰巴托市高中的外语教育提出了一项比较分析，旨在客观地评估英语和国际汉语在蒙古国外语教育中的地位及其作用。研究背景考虑到乌兰巴托作为全球城市的发展，其中英语已在国际交流和商务中占据重要位置，而随着中国在全球影响力的增长以及其中蒙俄经济走廊中的重要角色，学习国际汉语的需求亦逐渐增加。

该研究将通过分析乌兰巴托当前的外语教育方法，讨论其对教育发展和跨文化技能提升所带来的机遇。同时，研究也将探讨与文化保护和语言多样性相关的挑战。通过分析，本研究意在展示学习国际中文和英文的趋势与全球经济联系、文化交流及教育政策进展之间的一致性，并区分学习国际中文的地区性动机与全球普遍对英语的需求和价值观。

论文将讨论在认识到乌兰巴托独特的语言文化背景下，语言学习的重要性。在研究的结尾部分，将提供关于蒙古国外语教育未来发展的客观预测，并提出建议，主张采取灵活且具有前瞻性的教育策略。这些策略不仅要与本地和全球变化相适应，而且要着眼于培养具备全球技能的新一代，同时保持与蒙古国文化遗产的紧密联系。

关键词：国际汉语；英语；高中；

ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН НИЙГЭМШИЛ БА ТАНИН МЭДЭХҮЙН ХӨГЖЛИЙН ТАНДАХ СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

Баясгалан Э., Энхбаяр Б., Санжаабадам С., Лхагвасүрэн Ц., Баярмаа Б.,
Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн

Хураангуй

БСҮХ-ийн ХХСС-ын хамт олон нь хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн хөгжлийн танин мэдэхүй болон нийгэмшлийн хүрээнд тандах судалгаа хийсэн. Судалгааны үр дүнгээс харахад, ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүд танин мэдэхүйн хувьд, бодит дүрслэлийн сэтгэхүй давамгайлдаг ба үзэгдэл юмсыг хооронд нь харьцуулан адилтгаж ойлгодог ба харин бүтэц бүрэлдэхүүнд задлан шинжилж нэгтгэн дүгнэхдээ бэрхшээдэг талтай байна. Харин зан төлөвийн хувьд сэргэлэн цовоо, идэвхтэй, хөдөлгөөнтэй, заримдаа тэвчээргүй загнах гэх мэт тогтворгүй байна. Ялангуяа маш амархан ядрах, цочирдон уурлах хандлагатай байна. Энэ нь хүүхдүүдийн мэдээллийг тогтоох, анхаарлаа төвлөрүүлэх чадварт нь сөргөөр нөлөөлдөг байх магадлал өндөр юм. Харин ачаалал даах чадварын хувьд харилцан адилгүй байгаа ч дийлэнх хүүхдүүдийн хувьд дунджаас бага зэрэг дээгүүр түвшинд байгаа нь анхаарал татаж байна.

Түлхүүр үг: ялгаатай хэрэгцээ, танин мэдэхүйн хөгжил, нийгэмшлийн хөгжил.

SOME RESULTS OF A STUDY OF THE SOCIO-EMOTIONAL AND COGNITIVE DEVELOPMENT OF CHILDREN WITH SPECIAL EDUCATIONAL NEEDS

Sanjaabadam,S., Enkhbayar,B., Lkhagvasuren,Ts., Bayarmaa,B., Bayasgalan,E
Mongolian National Institute for Educational Research

Abstract

The Mongolian National Institute of Educational Research, Human Development Sector conducted a study on the cognitive and socio-emotional development of children with special educational needs. According to the results of the study, children with special educational needs are cognitively dominant in comprehending real images and understanding phenomena by comparing them with each other, but they have difficulties in analyzing and generalizing structure. As for behavior, it is cheerful, active, active, sometimes impatient, scolding, unbalanced, etc. In particular, there is a tendency to get tired and angry very easily. It is likely that this has a negative impact on children's ability to retain information and concentrate. However, it is worth noting that the ability to tolerate strain varies, but most children are slightly above average.

Keywords: special educational needs, cognitive development, socio-emotional development.

RESEARCH ON THE CONCEPT AND ATTITUDE OF INCLUSIVE EDUCATION AMONG KINDERGARTEN TEACHERS IN INNER MONGOLIA AUTONOMOUS REGION

Han Sarina

*Inner Mongolia University of Science and Technology, Baotou
Teacher's College*



Abstract

Мөн энэхүү илтгэлд Монгол Улсад 1926 оноос хүүхдийн амралт, зуслангийн эхлэл тавигдсан бөгөөд эдүгээ 60 зуслан, амралтын газар үйл ажиллагаа явуулж, жилдээ 70 мянга гаруй хүүхдийг амрааж, тэдний хувийн болон багийн хөгжлийг дэмжихэд хувь нэмрээ оруулж байгааг онцолсон болно.

Хүүхдийн амралт, зуслан нь хүүхдийн эрэлт хэрэгцээ, сонирхолд нийцсэн, тэдэнд зайлшгүй чухал чадваруудыг дэмжсэн, сайтар төлөвлөж боловсруулсан хөгжлийн хөтөлбөр, уг хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байр танхим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал хэрэгсэл болон байгалийн онцлог бүхий хөгжлийн орчин нөхцөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохицуулалт, дэмжлэгээр хангаж тусалж байх хөтөлбөрийн менежер гэсэн гурван тулгуурт бодлогын зохистой нэгдлийн үр дүнд л зорилгоо бүрэн хангадаг байна.

Түлхүүр үг: хөгжлийн төв, хөгжлийн хөтөлбөр, хөгжлийн менежер, хөгжлийн орчин, пионер, пионерын лагерь.

EVOLUTIONARY JOURNEY AND FUTURE TRENDS OF CHILDREN’S CAMPS IN MONGOLIA

(Illustrated by the International Children’s Complex Nairamdal)

Baavgai.Kh¹, Otgonbat,B²

¹International University of Ulaanbaatar

²International children’s complex Nairamdal

Abstract

A brief history of the development of children’s camps in Mongolia, including the International Children’s camp known as Nairamdal, is presented within the scope of this study. As well as, the contribution of Nairamdal to the development and social growth of children are examined with a focus on highlighting emerging trends within the field.

In addition, this presentation highlights the inception of children’s vacations and summer camps in Mongolia, which dates back to 1926. Currently, 60 camps are in operation, serving over 70,000 children annually, thereby significantly contributing to their development and participation.

A children’s camp embodies a meticulously planned and structured developmental program designed to address the needs and interests of children, nurturing their essential skills and abilities. It includes the provision of necessary facilities, equipment, materials, and natural surroundings conducive to implementing developmental programs. Furthermore, the camp environment, enriched with natural features, ensures optimal conditions for activities, all supervised by professionals. The comprehensive achievement of camp objectives relies on the seamless integration of three fundamental pillars: the developmental program, the environment for growth, and dedicated program managers.

Keywords: development center, developmental program, development manager, environment for growth, pioneer, pioneer camp.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БАГА НАСНЫ ТАЛААРХ ОРЧИН ҮЕИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН АСУУДАЛД

С.Одончимэг¹, Д.Байгалмаа²

¹АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны сургууль

²Дархан-Уул аймаг, 7 дугаар цэцэрлэг

Хураангуй

Сургуулийн өмнөх боловсролын асуудал нь дэлхийн хэмжээнд анхаарлаа хандуулах асуудлын нэг болж байна. Орчин үеийн боловсролын бодлогод – «детоцентризм» (хүн ам зүйч А.Вишневский) буюу хүүхэд болон гэр бүлийн үнэ цэнийг тэргүүн эгнээнд тавих шинэ үзэл баримтлал бий болсон. Өнөөдөр сургуулийн өмнөх боловсролын стратеги нь – хүүхдийн төлөөх бага нас байх естой бөгөөд үнэт зүйлийн баримжааг өөрчлөх шаардлагатай байна. Үүнд: Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь бие хүнийг нийгэмшүүлэх институт байх; хүүхэд сургуульд бэлтгэх бус харин сургууль, сурган хүмүүжүүлэгч нар хүүхдийг сургахад тохируулга хийх; сургуульд бэлтгэх бус харин эерэг нийгэмшүүлэлт, хувь хүний хөгжлийг дэмжих, хүүхдийн санаачлагыг дэмжих; суралцахуйд бэлтгэх бус харин хөгжихөд бэлэн байх г.м. Сургуулийн өмнөх боловсролын глобалчлал нь дэлхийн нийтийн үйл явц ба энэ нь нэг улсын асуудал биш юм. Орчин үеийн бага насны ойлголтын хувьсал нь шинэ ойлголтоор баяжин өөрчлөгдөж байна. Тухайлбал: цахим үе, мэдээллийн нийгэмшихүй, төлөвшөөгүй байдал, аутистик хүрээний эмгэг г.м. Мөн хүүхэд насны тоглоом аажимаар өөрчлөгдөж, алга болох, дээд мэдрэлийн сэтгэцийн үйл ажиллагаа болон хувь хүн төлөвших механизмын өөрчлөлт, харилцааны хэлбэр болон харилцах эв дүй гажих (үйлдлийн арга), хүүхдийн харилцаанд гэр бүлийг гадуур авч үзэх зэрэг асуудал нь тулгамдсан асуудал болж байна. Эдгээр асуудлын шийдэл, гарц нь боловсролын чанараар хангах шаардлагатай байна.

Түлхүүр үг: хүүхэд төвт үзэл, харилцаа, танин мэдэхүй, нийгэмшихүй, цахим үе, төлөвшил.

MODERN CONCEPTS IN CHILDHOOD

Odonchimeg,S¹, Baigalmaa,D²

Abstract

Preschool education is a zone of active discussions. A new concept has appeared in modern educational policy - “child-centrism”, which puts the value of the child and family at the forefront. The strategy provides for a change in value guidelines, where the kindergarten acts as an institution for the socialization of the individual; It is not the child who is preparing for school, but the school and the teacher who are preparing and adapting to the child. The changes are associated with the emergence of new phenomena: the digital generation, information socialization, infantilism, autism, displacement of the family beyond the child’s communication, and many others. etc. To solve emerging problems, it is necessary to ensure the quality of education, which, first of all, requires a change in the consciousness of adults, in particular teachers, parents, and politicians.

Keywords: child-centrism, communication, cognitive, socialization, digital era, formation.

ОЮУТАН ЗАЛУУЧУУДЫН ҮНЭТ ЗҮЙЛСЭД НОМЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Т.Оюунбилэг

ШУТИС-ийн БУХС

Хураангуй

Нийгмийн хэм хэмжээг тогтоож байдаг үнэт зүйл нь хүмүүсийн зан үйлийг зохицуулах эх сурвалж юм. Монголын уламжлалт, түүхэн ном зохиолууд нь хүүхэд, залуучуудын үнэт зүйл бүрэлдэн тогтоход хэрхэн нөлөөлж, хүмүүжил төлөвшилтөд ямар үүрэг гүйцэтгэж байгааг судлах нь чухал байна. Гаврилюк В.В, Трикоз Н.А нарын “Үнэт зүйлийн код” асуумжийг ашиглан монголын оюутан, залуучуудын үнэт зүйлийн баримжааг тодорхойлохын зэрэгцээ Жангар, Гэсэр, Монголын нууц товчоо, Оюунтүлхүүр зэрэг эртний, уламжлалт ном зохиолын агуулгад контент анализ хийж, статистик шинжилгээ хийсэн.

Үнэт зүйлийн кодын онолын шалгуураар оюутан залуучуудын хувьд эрүүл мэнд, аюулгүй байдал, гэр бүл, эрх чөлөө, харилцан туслалцах, шинийг эрж хайх, үнэнийг эрэлхийлэх зэрэг үнэт зүйлийн баримжааг чухалчлах хандлагатай байна. “Бусдын хэрэгцээг хангахад туслах, бусад хүмүүсийг дэмжихийг хичээх” нь чухал биш, гэр бүл болон өөрийгөө бөөцийлөх нь амьдралын утга учир нь болж байна. Ном зохиолын агуулгад хийсэн контент анализийн хувьд ч мөн адил витуаль болон амьдралын утга учрын үнэт зүйл давамгайлж байна.

Судалгааны тоон ба чанарын мэдээлэлд үндэслэн уламжлалт ном зохиолыг уншсан эсэх ба үнэт зүйлийн хоорондын хамаарлыг судлан үзэхэд Монголын нууц товчоог уншиж судалж буй оюутнуудын хувьд сайхан сэтгэл, харилцан туслалцах, гэр бүл, бусдын адил амьдрах, бусдаас ялгарах гэсэн үнэт зүйл бүрэлдэхэд нөлөөлөх байдал сул хамааралтай ($r=0.2$) байна. Оюунтүлхүүр зохиолыг тодорхой хэмжээгээр уншсан оюутнуудын хувьд эрүүл мэнд, аюулгүй байдал, гэр бүл, тэгш байдал, бусадтай адил амьдрах гэсэн үнэт зүйл бүрэлдэхэд нөлөөлөх байдал мөн адил сул хамааралтай ($r=0.2$) байна. Монголын нууц товчоог судалгаанд оролцсон оюутнуудын ихэнх нь (92.0 хувь) уншсан байгаа нь тэдгээрийн сурлагын амжилтанд ($r=0.31$) тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Судалгаанд оролцсон оюутнуудын 12.0 хувь нь чөлөөт цагаараа ном уншдаг, 2 оюутан тутмын 1 нь Гэсэр, Жангар туулийг огт уншаагүй байгаа нь энэхүү судалгааны ажлын үр дүнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байж болзошгүй.

Түлхүүр үг: үнэт зүйл, үнэт зүйлийн код, ном зохиол, номын засал, залуучууд, Z үеийнхэн.

THE IMPACT OF BOOK READING ON MONGOLIAN STUDENT’S VALUES

Oyunbileg, T

*School of Business Administration and
Humanities Mongolian University of Science and Technology*

Abstract

By helping social norms to be internalized, values are indirectly sources of relationship behavior. Likewise, history books have different meanings that shape values and influence social life. It seems important to reevaluate the role of values in social life in a society which is extremely distinguishable in history books.

An adaptation of Gavrilyuk’s value survey was used. Correlation analysis revealed significant differences between Mongolian students in value types and in history books. Altogether, it seems most important to investigate more detailed on the historical and social influences that shape individual and communal identities with regard to questions of history books and values. Conclusion of the secret history of the Mongols correlates to

-family ($r=.3$) significantly

-kindness, sustainability, integrity, compassion ($r=0.2$) weakly.

Keywords: value, value codes, book, book therapy, generation Z.

АНГЛИ ХЭЛ СУРАХ АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААР ЭЦЭГ ЭХ, СУРАЛЦАГЧДЫН ОЙЛГОЛТЫГ СУДЛАХ НЬ

Б.Энхзул¹

Т.Оюун-Эрдэнэ²

^{1,2}Мандах Их Сургууль

Хураангуй

Энэхүү судалгаагаар ахлах ангийн сурагчид, тэдний эцэг эхчүүд англи хэл сурахын ач холбогдлыг хэрхэн тодорхойлж байгааг судлахыг зорьсон. Ахлах ангийн сурагчид их, дээд сургуульд элсэн үргэлжлүүлэн суралцах зорилготой учир тэдний эцэг, эхийг мөн судалгаанд хамруулав. Тиймээс эдгээр сурагчдын англи хэл сурах үйл явцыг юу гэж үнэлдэг, хэр үр дүнтэй байгаа талаар ярилцлагаар эцэг эхээс тодрууллаа. Уг судалгаанд асуулга, ярилцлага бүхий судалгааны холимог арга зүйг ашиглаж, тоон судалгааны шинжилгээнд SPSS мөн чанарын судалгаанд учир шалтгааны онолыг тус тус ашигласан болно. Тоон судалгаанд найдвартай байдал, хүчин зүйл, хамаарал, регрессийн шинжилгээ тус тус хийв. Судалгааны үр дүнгээс суралцагчид болон тэдний эцэг, эхчүүд англи хэл сурахад ихээхэн ач холбогдол өгч байгаа бөгөөд суралцагчдын сэтгэл ханамж, өөрийн үнэлэмж, нийгмийн байр суурь, хэл-соёлын ойлголтод ихээхэн ач холбогдолтой байна. Ажил мэргэжлийн хувьд ахин дэвших үүднээс хүүхдүүдээ ахисан түвшинд англи хэл эзэмшүүлэхийг эцэг, эхчүүд эрмэлздэг нь ярилцлагын үр дүнгээс харагдаж байна. Түүнчлэн суралцагчид бие даан суралцахаас гадна цаашид мэргэжлийн багшийн тусламжтай англи хэл суралцахыг илүүд үзжээ.

Түлхүүр үг: англи хэл эзэмших, боловсрол, суралцагч ба эцэг эхийн ойлголт, ажил мэргэжлийн дэвшил, нийгэмд эзлэх байр суурь, өөрийн итгэл.

A STUDY ON THE PERCEPTIONS OF STUDENTS AND PARENTS REGARDING THE SIGNIFICANCE OF LEARNING ENGLISH

Enkhzul,B¹

Oyun-Erdene,T²

^{1,2} *Mandakh University*

Abstract

The purpose of the study was to determine the significance of English language learning for high school students and the level of understanding of their parents regarding the same. The research sample consisted of high school students along with their parents, as the latter plays a vital role in their children’s university entrance examination and further studies in tertiary education. The questionnaire comprised five categories of questions, encompassing career opportunities, social recognition, economic enhancement, language and cultural issues, and English for self-satisfaction and self-esteem. Moreover, the interview questions sought to understand the parents’ perception of their children’s English language learning and its impact on their academic performance. The research employed a mixed-method approach involving the analysis of both quantitative and qualitative data, using SPSS and grounded theory, respectively. The quantitative data analysis included factor analysis, reliability analysis, correlation analysis, and regression analysis. Based on the research findings, students attach significant importance to learning English, as it contributes to their self-satisfaction, self-esteem, social recognition, and language and cultural understanding. Parents expect their children to have advanced English proficiency that will help them progress in their careers. Finally, their children rely on professional teachers to teach self-directed learning, which will encourage them to study further.

Keywords: english acquisition, academic studies, comprehension of students and parents, career prosperity, social status, self-confidence.

МОНГОЛ ХҮҮХДИЙН СУРАХ ЧАДВАРЫН ӨНӨӨГИЙН АСУУДАЛД

Б.Солонго¹, Б.Ариунбаяр²

^{1,2} МУИС

Хураангуй

Бид дэлхий нийтийг хамарсан цар тахлын дараахан 12-13 настай сурагчдын унших чадварыг империк түвшинд шууд бус ажиглалтын аргаар судлан тодорхойллоо. Судалгаанд Булган аймгийн төвийн 1, сумын 5, Орхон аймгийн төвийн 4, сумын 1, Хөвсгөл аймгийн төвийн 1, сумын 4 нийт 16 сургуулийн 7 дугаар ангийн 16 бүлгийн 400 сурагчийг хамруулсан. Судалгаагаар 4 хүүхэд тутмын 3 нь унших техникийн доголдолтой байв. Бид нэгэн сумын сургуулийн 3-5-р ангийн 220 сурагчийн унших техникийг ажиглалтын аргаар судалж доголдлын шалтгааныг илрүүллээ. Унших техникт доголдох үндсэн хүчин зүйл нь “үгийн үсэг, үеийг сольж, гээлгүй амьсгал тохируулан зөв унших” аргад суралцаагүй байв. Арга эзэмшээгүй байгаа нь бага ангийн хүүхдийн хэлэхүйн артикуляцын системд тодорхой бэрхшээл үүссэнтэй холбоотой байна. Энэ нь хөл хорионы үеийн нөхцөл байдлаас нэгдүгээрт, танхимын бус нөхцөлд суралцах арга эзэмшүүлэх багшлахуйн чадамж дутмаг, хоёрдугаарт дэлгэц нь хүүхдийн анхаарал төвлөрлийг багаснаас шалтгаалсан байна. Бид энэ шалтгааныг засах арга зүйг боловсруулан гурван шатлалтай туршиж, сурагчдын ахиц амжилтыг гарааны, явцын, эцсийн байдлаар үнэлж үр дүнг тооцоолж байна. **Түлхүүр үг:** сурах арга барил, танин мэдэхүйн оюуны үйл, хэлний чадвар, унших чадвар.

CURRENT PROBLEMS ON LEARNING ABILITY OF CHILDREN IN MONGOLIA

Solongo, B¹, Ariunbayar, B²

^{1,2} National University of Mongolia

We empirically determined the reading ability of 12-13-year-old students immediately after the global pandemic by indirect observational methods. 400 students from 16 groups of 7th grade of 16 schools of Bulgan province capital 1, subprovince 5, Orkhon province capital 4, subprovince 1, Khuvsgul province capital 1, subprovince 4 were included in the study. According to the study, 3 out of 4 children had technical difficulties in reading. We studied the reading technique of 220 students of the 3rd-5th grade of a subprovince school by observational method and found out the cause of the defect. The main factor of failure in reading technique was not learning the method of “changing the letters and syllables of words, adjusting the breathing and reading correctly”. The lack of mastery of the method is related to certain difficulties in the speech articulation system of elementary school children. This is due to the situation during the curfew, firstly, the lack of teaching skills to learn in non-classroom conditions, and secondly, the screens reduce children’s attention span. We developed a methodology to address this issue and tested it in three stages, measuring student progress at baseline, progress, and final.

Keywords: learning style, cognitive intellectual ability, language ability, reading.

СУРГУУЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ДАМЖУУЛАН ХҮҮХЭД ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Д.Дэлгэрмаа¹, Ч.Анударь²

¹Монгол Улсын Боловсролын Их Сургууль

²Отгонтэнгэр их сургууль

Хураангуй

Боловсролын орчинд хүүхдэд хүрэх үйлчилгээг чанартай, үр өгөөжтэй болгох олон асуудлуудын нэг болох микро түвшний нөлөөллийн нэг нь сургуульд сэтгэл зүйч ажиллах, багш сурагчдын сэтгэл зүйн асуудлыг сэтгэл судлалын шинжлэх ухааны онол, арга зүйн үүднээс шийдвэрлэх явдал юм. Ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчдын насны хямралаас үүдэлтэй зөрчил, анги хамт олонд гадуурхагдах, өөртөө итгэлгүй болох, гэр бүлийн болон нийгмийн стрессийн асуудлаар хүүхэд хэнд, хаана хандахаа мэдэхгүй мухардалд орсноор амиа хорлох, сургуулиас гарах, гэрээсээ явах, сурах сонирхол буурах, гэр бүлийн орчинд эцэг эх хүүхдийн зөрчил хурцдах зэрэг асуудлууд тохиолдож байна.

Энэхүү асуудлыг бууруулах, тохирох арга хэмжээг авах үүднээс боловсролын салбарт шинээр үүсэн хөгжиж буй дэд тогтолцоо бол “Боловсролын сэтгэл зүйч” юм. Энэхүү шинэ тогтолцоо болон боловсролын сэтгэл зүйчдийг Монгол улсын хэмжээнд бүх ерөнхий боловсролын сургуульд ажиллуулах зорилтын дагуу ерөнхий боловсролын сургуульд боловсролын сэтгэл зүйчид мэргэшин ажиллаж байна. Боловсролын сэтгэл зүйчдийн үндсэн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх, ажлын нөхцөл, ажил үүргээ зохион байгуулахад тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, цаашид засан сайжруулах асуудлыг олох, илрүүлэх, тухайн үйл ажиллагааны дүгнэлт, холбогдох зөвлөмжийг боловсруулах үүднээс боловсролын сэтгэл зүйчдийн үйл ажиллагаанд мониторинг үнэлгээг 2 жил дараалан хийж байна. 2022-2023 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй боловсролын сэтгэл зүйчдийн 1 жилийн ажлын явцыг үнэлэх, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх зорилготой зохион байгуулагдсан мониторинг, үнэлгээний үр дүнгээс холбогдох зарим хэсгүүдийг энэхүү судалгааны ажилд тусгасан болно.

Түлхүүр үг: хүүхэд, боловсрол, асуудал, тогтолцоо.

CHILD DEVELOPMENT THROUGH THE ACTIVITIES OF THE SCHOOL PSYCHOLOGIST

Delgermaa,D¹, Anudari,Ch²

¹Mongolian University of Education

²Otgontenger university

Abstract

One of the micro-level influences, which is one of the many problems of making quality and beneficial services for children in the educational environment, is the work of psychologists in schools and solving the psychological problems of teachers and students from the perspective of psychological science theory and methodology. In the general education school environment, conflicts caused by the age crisis of students, exclusion from the class, loss of self-confidence, family and social stress issues, the child commits suicide due to not knowing who and where to turn to, dropping out of school, leaving home, losing interest in learning, parents in the family environment.

In order to reduce this problem and take appropriate measures, a newly developing sub-system in the field of education is “Educational Psychologist”. According to this new system and the goal of employing educational psychologists in all general education schools throughout Mongolia, educational psychologists are working as specialists in general education schools. Monitoring and evaluation of the activities of educational psychologists has been carried out for 2 years in a row in order to continuously the basic activities of educational psychologists, to find and detect difficulties in the organization of work conditions and duties, and to find and identify problems for further improvement, to develop conclusions and relevant recommendations. Recognizing the urgent need for specialized intervention, Mongolia has initiated a pioneering endeavor to embed educational psychologists across its general education schools. The aim is to provide targeted support and intervention to alleviate psychological distress and promote positive outcomes.

This research presents findings derived from two years of comprehensive monitoring and evaluation of educational psychologists’ activities within Ulaanbaatar general education schools during the academic year 2022-2023. The monitoring focuses on gauging the effectiveness of interventions, identifying operational challenges, and formulating actionable recommendations for continuous improvement.

Keywords: child, education, problem, system.

МОНГОЛ ХҮҮХДИЙН ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛСАН СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Ш.Ариунбаяр¹, Б.Чимгээ², Н.Сүнжидмаа³

^{1,2,3} Барилгын политехник коллеж

Хураангуй

Хүүхдийн ялгаатай хэрэгцээнд суурилсан сургалтын зөв зохион байгуулалт нь сургалтын чанарт нөлөөлөх эсэх нь судлаачдын сонирхлыг ихээхэн татаж байна.

Ховард Гарднер хүний оюун ухааныг нэг ерөнхий чадвар гэж тодорхойлохоос илүүтэйгээр тодорхой оюун ухаанд хуваахыг санал болгожээ. Оюун ухааны олон талт шинж чанарын тухай шинэ онолыг (1983) анх дэвшүүлжээ. Түүнийхээр бие даасан 9 шинж чанарыг тодорхойлох олон хувилбарт арга зүй байдгаас бид 108 асуулт бүхий хувилбарыг сонгон авч мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын 1142 суралцагчдад хэрэглэн, хувь хүн бүрийг тухайлан тодорхойлон авч үзэхээс гадна ирээдүйд сонгон суралцах мэргэжил нь тэдний онцлогт тохирох эсэхийг нарийвчлан үзлээ.

Судалгаанд хамрагдсан нийт суралцагчдын бие хөдөлгөөний оюун ухаан, өөрийгөө танин мэдэхүйн оюун ухаан, харилцааны оюун ухааны шинж чанар хамгийн өндөр, харин хэл ярианы оюун ухаан хамгийн бага байгаа нь эдгээр оюуны шинж чанарт суурилсан арга зүйгээр сургалтыг зохион байгуулах нь илүү үр дүнтэй байх юм.

Багш нар ялгаатай шинж чанарыг харгалзан үзэж сургалтын арга зүйг боловсруулан, STEAM хөтөлбөрийг хэрэгжүүлж буй талаарх харьцуулан судалсан судалгааны үр дүн болон амжилттай суралцах аргуудыг танилцуулж байна.

Мөн суралцагчдын 79,9% нь өөрийн оюун ухааны шинж чанарт нийцээгүй мэргэжлийг сонгон суралцахаар төлөвлөсөн байгаа нь судлаачид цаашид энэ сэдвээр дэлгэрүүлэн судлах шаардлагатай гэж үзлээ.

Түлхүүр үг: оюун ухааны шинж чанар, шинжлэх ухаан, логик, хэл яриа, хөдөлгөөн, хөгжим, оршихуй, харилцаа, байгаль.

LEARNING METHODS BASED ON THE DIFFERENT NEEDS OF MONGOLIAN CHILDREN

Ariunbayar,Sh¹, Chimgee,B², Sunjidmaa,N³

^{1,2,3} Polytechnic college

Abstract

Whether the proper organization of education based on the different needs of children will affect the quality of education is of great interest to researchers.

Rather than defining human intelligence as one general ability, Howard Gardner proposed dividing it into specific intelligences. A new theory about the multifaceted nature of intelligence was first proposed in 1983. According to him, there is a multivariate methodology for determining 9 independent characteristics, so we selected a version with 108 questions and applied it to 1142 students of vocational and technical education and training institutions. In addition to considering each individual in detail, it was also considered in detail whether the profession of elective study in the future is suitable for their characteristics.

The physical intelligence, self-awareness intelligence, and communication intelligence characteristics of all the students involved in the study are the highest, but the language intelligence is the lowest, so it would be more effective to organize training based on these intellectual characteristics.

Teachers have developed a teaching methodology that takes into account the different characteristics, and the results of a comparative study of the implementation of the STEAM program and successful learning methods are presented.

Also, 79.9% of the students planned to choose a profession that did not match their intellectual characteristics, so the researchers considered that it is necessary to study this topic in detail in the future.

Keywords: characteristic of mind, science, logic, language, movement, music, existence, relationship, nature.

МОНГОЛ ХҮҮХДИЙН СУДАЛГААНЫ ХӨГЖИЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ

Э.Нармандах, Л.Даваадорж

Орхон аймгийн Ерөнхий боловсролын 13-р сургууль

Хураангуй

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.1.21-т заасан сурагчдын сурлагын амжилтад нөлөөлөгч хүчин зүйлийн судалгааг тогтмол хийж, үр дүнд үндэслэн бодлого, төлөвлөлт хийж хэвших, 2.3.3 Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна...” гэсэн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор багш, судлаачид ажиллаж байгаа билээ.

Үүний нэгэн адил бид “Өсвөр насны хүүхдийн (11-18 нас) сэтгэл зүйн тулгамдсан нийтлэг асуудлууд, түүнд нөлөөлөгч хүчин зүйл” судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу Монголчуудын хүүхдээ судлан шинжих арга ухааны үүсэл хөгжил, өнөөгийн байдлыг тодорхойлох бүтээлийн судалгааг хийж эхлээд буй. Үүний хүрээнд 1-рт: Хүүхдийг сургах (мэдлэг олгох), хүмүүжүүлэх (төлөвшүүлэх) үйлийг зөв чиглүүлэхийн тулд хэрхэн судалж таньж байсан уламжлалт арга ухаан нь орчин үеийн судалгааны хэв маяг болж хөгжиж ирсэн дэвшилтэт өөрчлөлтийг тоймлон дүгнэх оролдлогыг хийв. 2-рт: Нийгмийн хариуцлагыг ухамсарлах болон ёс зүйтэй харилцах чадварыг хүүхдэд төлөвшүүлэх үйл явцад гарах нийгэм-сэтгэл зүйн үзэгдэл, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлэхэд “Сэтгэлийн хөдөлгөөн, зан үйлийн судалгаа”, “Танин мэдэхүйн хөгжлийн судалгаа” гэсэн чиглэлээр судлагдсан байдал, өнөөгийн зорилтот асуудлыг тодорхойлохыг хичээлээ.

Багшлахуй, суралцахуйд үүсэх түгээмэл асуудлыг шийдвэрлэхэд судлаачийн байр сууринаас хандаж, мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг хүргэх нийгмийн шаардлагад нийцүүлэхийг зорьсон болно.

Түлхүүр үг: нийгэмшил, уламжлал, шинэчлэл, судалгааны хөгжил.

MONGOLIAN CHILDREN’S RESEARCH DEVELOPMENT, CURRENT STATUS AND PRACTICAL SIGNIFICANCE

Narmandakh,E¹, Davaadorj,L²

^{1,2} Orkhon Province, 13th School

Abstract

As part of the long-term development policy of Mongolia “Vision 2050” in 2021-2030, as stated in Section 2.1.21, conduct research on the factors influencing the academic success of students, and practice policy and planning based on the results, 2.3.3 “Mongolia Based on comprehensive research on human development, the government implements policies and programs to protect the rights of the population, families, children, youth, workers, the elderly, people with disabilities, and migrants, to provide equal basic social services, and to support employment. teachers and researchers are working in order to ensure the implementation of the provision will improve...”

In the same way, according to the research work plan “Common psychological problems of adolescents (11-18 years old) and their influencing factors”, we have started researching the origin and development of Mongolian children’s research methods and determining the current situation. In this context, 1st: An attempt was made to summarize the progressive changes that have been developed into the modern research style of the traditional methods of studying how to properly guide children’s education (knowledge), humanization (maturity). 2nd: Researched in the fields of “Study of Mental Movement and Behavior” and “Research of Cognitive Development” in the process of developing children’s awareness of social responsibility and the ability to communicate ethically, and the current target Learn to define the problem.

It is intended to meet the social requirements of providing professional and methodological consulting services by approaching the solution of common problems in teaching and learning from a researcher’s point of view.

Keywords: socialization, tradition, innovation, research development.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН БОЛОВСРОЛЫГ ЦЭЦЭРЛЭГИЙН СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТУРШИЛТ СУДАЛГАА

Б.Баярмаа¹, Ө.Амарзаяа², Б.Жавзандулам³, Л.Цог-Эрдэнэ⁴

^{1,2} Нийслэлийн БЗД -ийн 167 дугаар цэцэрлэг

³ МУБИС

⁴ НҮБ-ийн залуучуудын зөвлөх хороо

Хураангуй

Нэгдсэн үндэсний байгууллагаас тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маяг, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх хэмээн тогтвортой хөгжлийн 17 зорилтын дөрөвт тавьсан байдаг.

Дэлхийн хэмжээнд 1 жилд 7 тэрбум тонн С2 агаар мандалд цацагддаг. Үүний ихэнх нь ой түймэр, нүүрс, байгалийн хий, газрын тос зэрэг түлшний шаталтаас ялгардаг. Нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгарал өндөр байгаад цаг уурын хямрал үүсэж аадар бороо, үер, их хэмжээний цас, зуд, элсний нүүдэл, салхи болон далайн шуурга, газар хөдлөлт, ган гачиг, хуурайшилт зэрэг байгалийн үзэгдлүүд нь эрсдэлтэй нөхцөлүүдийг бий болгож байна. Цаг уурт ноцтой өөрчлөлт орж дэлхийн эко систем эрс өөрчлөгдөж, ирээдүйд амьдрах нөхцөл хүндрэх эрсдэл бий болоод байна. Дэлхийн хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь хүн тус бүрийн үүрэг оролцоо чухал гэж үзэж байгууллагын удирдлага, эцэг эх, хүүхдүүд, сурган хүмүүжүүлэгчид хувь нэмрээ оруулах зорилгоор энэхүү туршилт судалгааг улсын цэцэрлэгт зохион байгуулав.

Судалгаанд оролцогч цэцэрлэг нь сургалтын хөтөлбөрийн агуулгадаа тогтвортой хөгжлийн боловсролын зорилтоос оруулж баяжилт хийсэн нь хүүхдүүдийг цэцэрлэгээс гадна амьдралд цаг тухай бүрд хэрэглэх мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт үйл ажиллагааг туршиж, ажиглалт хийсэн. Сургалтыг үр дүнг харахад суралцагч хүүхдүүд орчны юмсын учир шалтгааныг таньж, хоорондын уялдаа холбоог ойлгож, нийгмийн амьдралд тулгарах бэрхшээлийг бие даан болон бусадтай хамтран шийдвэрлэхэд суралцсан. Бидний сургалтын арга нь бодит амьдралд тулгуурлан хүүхдүүдийн гэр бүлдээ, олон нийтийн газар ашиглаж буй хэрэглэл, эд зүйлсээр сургалтыг явуулдаг бөгөөд хүүхэд өөрийн биеэр үйлдэж үзэн, шийдвэр гаргах нь илүү үр дүнтэй байгаа нь харагдаж байна.

Түлхүүр үг: уур амьсгалын өөрчлөлт, цэцэрлэг, сургалт, үйл ажиллагаа.

A STUDY OF CLIMATE CHANGE EDUCATION IMPLEMENTATION IN KINDERGARTEN’S LEARNING AND PRACTICE

B.Bayarmaa¹, U.Amarzaya², B.Javzandulam³, L.Tsog-Erdene⁴

^{1,2} Kindergarten No167, Bayanzurkh District, UB

³School of Pre-School Education, MNUE

⁴United Nations Youth Advisory Panel in Mongolia

Abstract

The United Nations Organization has the 17 goals of sustainable development through sustainable development education and the fourth goal is to protect traditional customs, preserve the environment, promote environmentally friendly lifestyles, and cultivate a culture of resource-saving and efficient consumption.

Globally, 7 billion tons of CO₂ are emitted into the atmosphere annually. Most of this comes from deforestation, burning fossil fuels such as coal, natural gas, and oil. High levels of greenhouse gas emissions per capita have led to a climate crisis, resulting in extreme weather events such as heavy rains, floods, snowstorms, droughts, sandstorms, hurricanes, earthquakes, and tsunamis, creating hazardous conditions. The drastic changes in climate are altering the world’s ecosystems, posing future threats to living conditions. Recognizing the crucial role each individual play in mitigating global greenhouse gas emissions, a pilot study was conducted in a national kindergarten to engage the organization’s management, parents, children, and educators.

The participating kindergarten enriched its curriculum by incorporating sustainable development education objectives, implementing and observing educational activities designed to enhance children’s knowledge and skills for life beyond kindergarten. Upon reviewing the training outcomes, students learned to identify environmental issues, comprehend their interconnections, and independently or collaboratively address societal challenges. Our teaching approach is experiential, utilizing everyday materials and objects familiar to children in their homes and communities.

Keywords: climate crisis, kindergarten, training, educational activity.

АХЛАХ АНГИЙН СУРАГЧДЫН БҮТЭЭЛЧЭЭР УНШИХ ҮЙЛ ЯВЦАД ХИЙСЭН СУДАЛГАА

Ц.Буянхишиг

Дархан-Уул аймгийн Оюуны ирээдүй цогцолбор сургууль

Хураангуй

Бүтээлч сэтгэхүйтэй иргэн л бүтээлч чадвартай байна. Тэгэхээр бүтээлч сэтгэхүйг хэрхэн бий болгох вэ?... Бүтээлчээр унших чадварт суралцуулснаар бүтээлч сэтгэхүйг төлөвшүүлнэ гэж дэлхий нийтээрээ үзэж байна. Бүтээлч уншлагын онолын үндэс нь конструктив онол бөгөөд сурагч нэг бүрийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх гол арга зам бол “БҮТЭЭЛЧЭЭР НОМ уншуулах” явдал юм. Өөрөөр хэлбэл хүн өөрийн бодож олсон шинэ санаанд урамшиж дотроо хөгжиж байдаг бөгөөд чухам тэр санааг олохын тулд ухаарч, бүтээж унших болно.

Иймд ахлах ангийн сурагчдын бүтээлчээр унших чадварт судалгаа хийлээ. Судалгаагаар сурагчдын 84,6% нь ном унших дуртай, ач холбогдлыг нь мэддэг мөртлөө 20,5% нь тогтмол уншдаг байна. Яагаад ийм их зөрөөтэй байна вэ? гэдэг нь энэхүү илтгэлийн гол асуудал юм.

Бүтээлчээр уншина гэдэг нь хамгийн энгийнээр өөрөө, өөртөө нээлт хийнэ гэсэн үг юм. Хүн өөрөө бодож, сэтгэж хөдөлмөрлөж олсон зүйлдээ их хайртай бөгөөд сэтгэл хангалуун байдаг. Сурагчдын ном унших үйлийг Блүүмийн таксономоор шинжилж үзвэл эхний 1-3-р шатанд байна гэж дүгнэв. Мөн цаашид бүтээлчээр унших арга барил эзэмших асуудлыг судлан үзэх шаардлагатай байна.

Түлхүүр үг: бүтээлч сэтгэхүй, бүтээлч чадвар, бүтээлч уншлага, хэл, соёл.

RESEARCH ON THE CREATIVE READING PROCESS OF HIGH SCHOOL STUDENTS

Buyankhishig, Ts

Oyunii ireedui Complex School, Darkhan Province

Abstract

Only a citizen with a creative mind can be creative. So, how to create creative thinking?... The world believes that creative thinking can be cultivated by learning to read creatively. The basis of the theory of creative reading is constructive theory, and the main way to develop the creative thinking of each student is to “READ BOOKS CREATIVELY”. In other words, a person is encouraged by the new ideas he has come up with and develops within himself, and he will understand, create and read in order to find those ideas.

Therefore, a study was conducted on the creative reading ability of high school students. According to the research, 84.6% of students like to read and know its importance, but only 20.5% read regularly. Why is there such a difference? is the main issue of this report.

To read creatively means, in the simplest terms, to discover yourself. A person loves and is satisfied with what he finds by thinking and working on his own. Analyzing the students' reading according to Bloom's taxonomy, it was concluded that they are in the first stage 1-3. Also, it is necessary to study the issue of acquiring creative reading methods in the future.

Keywords: critical thinking, creative abilities, creative reading, language and culture.

БАГА АНГИЙН СУРАГЧДЫГ ТОГЛООМЫН АРГААР ХӨГЖҮҮЛЭХ НЬ (I-III ангийн жишээн дээр)

Ч.Амгаланбямба

Нийслэлийн ерөнхий боловсролын 33-р сургууль

Оршил

Монгол Улсын боловсролын салбарт өөрчлөлт шинэчлэл эрчимтэй явагдаж, Боловсролын тухай хууль, Биеийн тамир спортын тухай хууль боловсруулагдан мөрдөгдөж байна. Биеийн тамир спортын болон боловсролын салбарын хөгжлийн чиг, хандлагын дагуу хуулийн нэмэлт өөрчлөлтүүд хийгдэж, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд дараалан гарч хэрэгжин .өөрчлөлт, шинэчлэл тасралтгүй явагдаж байна.

Судалгааны ажлын зорилго

Бага ангийн биеийн тамирын хичээлд тоглоомын аргыг хэрэглэж, үр дүнг нь тооцоход судалгааны ажлын зорилго оршино.

Зорилт

- Бага ангийн сурагчдын бие бялдрын хөгжлийн онцлогийг судлах
- ЕБС-ийн 1-3 дугаар ангийн биеийн тамирын хичээлийн сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх
- Бага ангийн биеийн тамирын хичээлийг хөдөлгөөнт тоглоомын аргаар зохион байгуулах арга зүйн хувилбарыг боловсруулан, турших
- Бага ангийн сурагчдын бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн түвшинг тодорхойлох

Бага ангийн сурагчдын үндсэн хэрэгцээ нь тоглоом байдагт үндэслэн янз бүрийн хөдөлгөөнт тоглоомоор дамжуулан хүүхдийг хөгжүүлнэ. Хүүхдийн төрөлхийн хөдөлгөөн, мэдрэмж дээр тулгуурлан шинэ хөдөлгөөний эв дүй олгохдоо үзүүлэх, дуурайх, дүрслэх аргуудыг ашиглан хүүхэд өөрөө дасгал хөдөлгөөнийг туршиж хийж үзэх бололцоог нэмэгдүүлэх нь чухал байна.



<https://www.mnier.mn>



<https://www.facebook.com/educationalresearchmgl>



GOO DESIGN